# "ТӨСВИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГАА 2019"
## МОНГОЛ УЛСЫН ДҮНГЭЭС

| Ил тод байдал | Олон нийтийн оролцоо | Төсвийн хяналт |
|---|---|---|
| **56** /100 (Төсвийн нээлттэй байдлын индексийн оноо) | **15** /100 | **80** /100 |




Төсвийн нээлттэй байдлын олон улсын 2019 оны үнэлгээгээр Монгол Улсын төсвийн ил тод байдал болон төсөвт тавих хяналтын түвшинд ахиц гарсан нь сайшаалтай. Харин төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо нэн сул хэвээр байна. Нийт авбал зохих 100 онооноос төсвийн ил тод байдлаар 56, төсвийн хяналтаар 80 авсан бол иргэдийн оролцоогоор 15 авчээ.

## ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ОЛОН НИЙТ ОРОЛЦОХ БОЛОМЖ

Төсвийн үйл явцын үе шатаар (оноо)

| **0** /100 | **22** /100 | **25** /100 | **33** /100 |
|---|---|---|---|
| Боловсруулах (Засгийн газар) | Батлах (Хууль тогтоох байгууллага) | Хэрэгжүүлэх (Засгийн газар) | Аудит хийх (Аудитын дээд байгууллага) |

### Иргэдийн оролцоог дээшлүүлэх чиглэлээрх Зөвлөмж

**Монгол Улсын Их Хуралд:**

- Олон нийтийн, эсвэл иргэний нийгмийн байгууллагын аливаа төлөөлөгч төсөв батлагдахаас өмнөх хэлэлцүүлгийн үеэр болон аудитын тайлангийн хэлэлцүүлгийн үеэр сонсголд оролцож мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх.

**Сангийн яаманд:**

- Төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлж эхлэх.
- Эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг шууд, эсвэл тэдгээрийг төлөөлдөг иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан төсвийн хэлэлцүүлэгт идэвхтэй татан оролцуулах.

**Үндэсний аудитын газарт:**

- Холбогдох аудитын шалгалт хийх үйл явцад олон нийт хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бий болгох.

## ТӨСВИЙН ХЯНАЛТ

Хяналтын байгууллагуудаар (оноо)

| Хууль тогтоох байгууллагын хяналт | Аудитын хяналт |
|---|---|
|   |   |

### Төсвийн хяналтыг дээшлүүлэх чиглэлээрх Зөвлөмж

**Монгол Улсын Их Хуралд:**

- Хууль тогтоох байгууллагын байнгын хорооноос төсвийн гүйцэтгэлийн жилийн явцын тайланг хэлэлцэж, гарсан дүгнэлтийг цахимаар нийтэлж байх.
- Төсвийн жилийн дундуур төсвийн хөрөнгийн хуваарилалтыг захиргааны нэгжүүдийн хооронд шилжүүлэх тохиолдолд хууль тогтоох байгууллагатай зайлшгүй зөвшилцдөг байх.

**Үндэсний аудитын газарт:**

- Аудит хийх үйл явцыг хөндлөнгийн байгууллагаар нягтлуулах.

Дэлгэрэнгүйг http://forum.mn/index.php?sel=content&obj_id=5874 цахим хуудаснаас үзнэ үү.

Эх сурвалж: International Budget Partnership (2020). Open Budget Survey 2019 (www.internationalbudget.org/open-budget-survey).